

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2011оны 371/ТАА дугаар сарын 08-ны өдрийн  
А/29 дугаар тушаалын хавсралт.



Архивын баримтын нэгдсэн тооллого  
явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч	А.Болдмаа	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Н.Өлзийжаргал Б.Батсайхан Г.Бямбасайхан Ж.Болдбаатар Ц.Бямбасүрэн С.Эрдэнэбат С.Бямбажав Д.Энхбаяр М.Алтангэрэл Ц.Ганболд Б.Батсайхан	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн Багануур дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Баянзүрх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Налайх дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Сүхбаатар дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Хан-Уул дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга
Нарийн бичиг:	С.Саранцэцэг	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн



91

## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 1/29

Улаанбаатар хот

### Архивын баримтын нэгдсэн тооллого явуулах тухай

Монгол Улсын "Архивын тухай" хуулийн 9 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2011 оны зорилтын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний 5.14 дүгээр зүйлийн 3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2011 оны 250 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороодын хэмжээнд хадгалагдаж байгаа архивын баримтын тоо хэмжээг гаргах, хадгалалт хамгаалалтын нөхцөл байдлыг тогтоох, улмаар цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох зорилгоор архивын баримтанд нэгдсэн тооллого явуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Байгууллагадаа архивын баримтын тооллого явуулах "Салбар ажлын хэсэг"-ийг томилон Нийслэлийн Засаг даргын 2011 оны 250 дугаар захирамжийн гуравдугаар хавсралтаар батлагдсан удирдамжид заасны дагуу тооллогын ажлыг чанартай явуулж, 2011 оны 06 дугаар сарын 20-ны дотор багтаан дүн мэдээ гаргаж ажиллахыг дүүргүүдийн Биеийн тамир, спортын хороодын дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Тооллогын ажилд шаардагдах 315000 /гурван зуун арван таван мянган/ төгрөгийг төлбөр хураамж, бусад зардлаас гаргахыг ня-бо Ж.Цэдэнсодномд зөвшөөрсүгэй.

Дөрөв. Архивын баримтанд тооллого явуулах Салбар ажлын хэсгүүдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дүн мэдээг 2011 оны 07 дугаар сарын 01-ний дотор нэгтгэж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан Нийслэл, Дүүргүүдийн Биеийн тамир, спортын газрын дарга нарын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн ахлагч А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД